

# СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/08/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
Сүхбаатар сум 2024 он	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.mn">bolort@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-12
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	13-16
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. Аудитын тайлан	17-18
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. Аудитын илрүүлэлт	20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21-22

## **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Э.ГАНЦЭЦЭГ ТАНАА**

2024 оор 75 № СЭА-2024/08/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосноос голлон шалтгаалж тус газрын 2023 оны нийт зардал өмнөх оноос 35.8 хувиар нэмэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг үндсэн цалингийн дунджаас тооцож олгон, 107,550.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар нь тайлант онд “Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлнэ” зорилго дэвшүүлж, 5 зорилт, 51 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 74.7 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,702,169.00</b>	<b>34,137,342.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>40,000.00</b>	<b>14,040,000.00</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>40,000.00</b>	<b>14,040,000.00</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>40,000.00</b>	<b>14,040,000.00</b>
31211	Төрийн сангийн харилцах	40,000.00	14,040,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,662,169.00</b>	<b>20,097,342.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>13,662,169.00</b>	<b>20,097,342.00</b>
35410	Бичиг хэргийн материал	979,575.00	-
35420	Аж ахуйн материал	9,960,077.00	16,872,427.00
35430	Сэлбэг хэрэгсэл	-	760,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,722,517.00	2,464,915.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,158,882,828.51</b>	<b>1,120,096,140.37</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,158,882,828.51</b>	<b>1,120,096,140.37</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,115,752,781.37</b>	<b>1,076,972,446.15</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,049,878,122.01	1,049,878,122.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(125,334,653.07)	(158,693,750.55)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	89,000,000.00	77,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(41,638,888.87)	(27,472,222.19)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	203,556,622.67	189,326,002.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(101,121,493.00)	(80,337,883.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	87,067,658.60	90,077,358.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(54,128,594.55)	(70,428,434.12)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,227,164.70	11,227,164.70
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,403,017.12)	(4,253,771.40)
39217	Ном	649,860.00	649,860.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>43,130,047.14</b>	<b>43,123,694.22</b>
39301	Программ хангамж	1,245,411.80	1,245,411.80
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,233,764.66)	(1,240,117.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	43,118,400.00	43,118,400.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,172,584,997.51</b>	<b>1,154,233,482.37</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,172,584,997.51</b>	<b>1,154,233,482.37</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,172,584,997.51</b>	<b>1,154,233,482.37</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	363,793,993.87	363,793,993.87
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	363,793,993.87	363,793,993.87
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>216,427,966.94</b>	<b>198,076,451.80</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	257,904,458.51	216,427,966.94
51220	Тайлант үеийн үр дүн	(41,476,491.57)	(18,351,515.14)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	592,363,036.70	592,363,036.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,172,584,997.51</b>	<b>1,154,233,482.37</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,424,725,728.36</b>	<b>1,973,018,857.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>56,615,628.36</b>	<b>53,319,580.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>56,615,628.36</b>	<b>53,319,580.00</b>
120009	Бусад орлого	-	43,647,400.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	54,303,758.36	5,727,480.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,311,870.00	3,944,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,368,110,100.00</b>	<b>1,919,699,277.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,357,310,100.00</b>	<b>1,919,699,277.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,357,310,100.00	1,919,699,277.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,800,000.00</b>	<b>-</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,800,000.00	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,466,202,219.93</b>	<b>1,991,370,372.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,466,202,219.93</b>	<b>1,991,370,372.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,406,652,931.14</b>	<b>1,872,152,592.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,017,841,514.40</b>	<b>1,445,954,998.61</b>
210101	Үндсэн цалин	708,737,118.00	889,526,419.76
210102	Нэмэгдэл	247,762,654.40	379,062,344.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,871,000.00	39,451,360.00
210104	Урамшуулал	37,470,742.00	137,914,874.85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>128,374,036.74</b>	<b>180,081,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	87,900,896.65	125,072,780.51
210202	Тэтгэмжийн даатгал	10,341,281.85	14,119,946.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,185,665.59	11,031,957.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,995,108.33	2,714,219.58
210205	Эрүүл мэндийн даатгал	19,951,084.32	27,142,196.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,854,930.07</b>	<b>60,544,120.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	35,153,768.07	46,207,828.34
210302	Түлш, халаалт	3,010,000.00	5,540,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,691,162.00	8,796,292.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,885,818.00</b>	<b>50,437,772.73</b>
210401	Бичиг хэрэг	14,549,025.00	17,158,965.00
210402	Тээвэр, шатахуун	11,484,683.00	14,017,602.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,560,740.00	12,267,755.73
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,197,770.00	6,618,450.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,499,047.00</b>	<b>11,239,600.00</b>
210604	Урсгал засвар	33,499,047.00	11,239,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,673,900.00</b>	<b>14,349,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,673,900.00	14,349,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,232,643.00</b>	<b>9,387,628.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,495,012.00	7,596,821.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,294,175.00	1,568,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,144.00	137,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	-
210807	Газрын төлбөр	40,812.00	18,987.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>113,291,041.93</b>	<b>100,157,773.14</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,291,041.93	100,157,773.14
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,549,288.79</b>	<b>119,217,779.32</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,960,000.00</b>	<b>102,968,677.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	101,168,677.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,960,000.00	1,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,589,288.79</b>	<b>16,249,102.32</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,789,288.79	16,249,102.32
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,800,000.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>(41,476,491.57)</b>	<b>(18,351,515.14)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>(41,476,491.57)</b>	<b>(18,351,515.14)</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,374,110,100.00</b>	<b>1,933,699,277.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,000,000.00</b>	<b>14,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,000,000.00</b>	<b>14,000,000.00</b>
120009	Бусад орлого	6,000,000.00	14,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,368,110,100.00</b>	<b>1,919,699,277.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,357,310,100.00</b>	<b>1,919,699,277.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,357,310,100.00	1,919,699,277.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>10,800,000.00</b>	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,800,000.00	-
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,360,070,100.00</b>	<b>1,907,703,072.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,360,070,100.00</b>	<b>1,907,703,072.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,300,520,811.21</b>	<b>1,788,485,292.68</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,017,841,514.40</b>	<b>1,459,954,998.61</b>
210101	Үндсэн цалин	708,737,118.00	903,526,419.76
210102	Нэмэгдэл	247,762,654.40	379,062,344.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,871,000.00	39,451,360.00
210104	Урамшуулал	37,470,742.00	137,914,874.85
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>128,374,036.74</b>	<b>180,081,100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	87,900,896.65	125,072,780.51
210202	Тэтгэмжийн даатгал	10,341,281.85	14,119,946.61
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,185,665.59	11,031,957.30
210204	Ажилгүйдлийн даатгал	1,995,108.33	2,714,219.58
210205	Эрүүл мэндийн даатгал	19,951,084.32	27,142,196.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,814,930.07</b>	<b>60,504,120.34</b>
210301	Гэрэл, цахилгаан	35,153,768.07	46,207,828.34
210302	Түлш, халаалт	3,970,000.00	5,500,000.00
210303	Цэвэр, бохир ус	8,691,162.00	8,796,292.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,768,740.00</b>	<b>51,400,245.73</b>
210401	Бичиг хэрэг	15,528,600.00	16,175,890.00
210402	Тээвэр, шатахуун	12,187,500.00	13,800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,560,740.00	12,267,755.73
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	1,176,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	93,600.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,398,300.00	7,605,600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>316,000.00</b>	<b>158,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	316,000.00	158,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>33,499,047.00</b>	<b>11,999,600.00</b>
210604	Урсгал засвар	33,499,047.00	11,999,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,673,900.00</b>	<b>14,349,600.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,673,900.00	14,349,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,232,643.00</b>	<b>9,387,628.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,495,012.00	7,596,821.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,294,175.00	1,568,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	111,144.00	137,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	-
210807	Газрын төлбөр	40,812.00	18,987.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,000,000.00</b>	<b>650,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,000,000.00	650,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,549,288.79</b>	<b>119,217,779.32</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,960,000.00</b>	<b>102,968,677.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	101,168,677.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,960,000.00	1,800,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>51,589,288.79</b>	<b>16,249,102.32</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	49,789,288.79	16,249,102.32
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,800,000.00	-
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>14,040,000.00</b>	<b>25,996,205.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>14,000,000.00</b>	<b>11,996,205.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,000,000.00</b>	<b>11,996,205.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>14,000,000.00</b>	<b>11,996,205.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,000,000.00	11,996,205.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(14,000,000.00)</b>	<b>(11,996,205.00)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>40,000.00</b>	<b>14,000,000.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	40,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	40,000.00	14,040,000.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>257,904,458.51</b>	<b>1,214,061,489.08</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>257,904,458.51</b>	<b>1,214,061,489.08</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	<b>(41,476,491.57)</b>	<b>(41,476,491.57)</b>
10	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>216,427,966.94</b>	<b>1,172,584,997.51</b>
11	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>216,427,966.94</b>	<b>1,172,584,997.51</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>216,427,966.94</b>	<b>1,172,584,997.51</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	<b>(18,351,515.14)</b>	<b>(18,351,515.14)</b>
20	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>363,793,993.87</b>	<b>592,363,036.70</b>	<b>198,076,451.80</b>	<b>1,154,233,482.37</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,027,449,600.00</b>	<b>1,903,450,174.68</b>	<b>123,999,425.32</b>	<b>93.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,027,449,600.00</b>	<b>1,903,450,174.68</b>	<b>123,999,425.32</b>	<b>93.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,816,730,600.00</b>	<b>1,800,481,497.68</b>	<b>16,249,102.32</b>	<b>99.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,463,988,400.00</b>	<b>1,459,954,998.61</b>	<b>4,033,401.39</b>	<b>99.72</b>
210101	Үндсэн цалин	932,405,600.00	903,526,419.76	<b>28,879,180.24</b>	<b>96.90</b>
210102	Нэмэгдэл	388,220,300.00	379,062,344.00	<b>9,157,956.00</b>	<b>97.64</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,766,400.00	39,451,360.00	<b>19,315,040.00</b>	<b>67.13</b>
210104	Урамшуулал	84,596,100.00	137,914,874.85	<b>-53,318,774.85</b>	<b>163.03</b>
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>180,081,100.00</b>	<b>180,081,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	125,884,800.00	125,072,780.51	<b>812,019.49</b>	<b>99.35</b>
210202	Тэтгэмжийн даатгал	13,549,100.00	14,119,946.61	<b>-570,846.61</b>	<b>104.21</b>
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,839,300.00	11,031,957.30	<b>-192,657.30</b>	<b>101.78</b>
210204	Ажилгүйдлийн даатгал	2,709,800.00	2,714,219.58	<b>-4,419.58</b>	<b>100.16</b>
210205	Эрүүл мэндийн даатгал	27,098,100.00	27,142,196.00	<b>-44,096.00</b>	<b>100.16</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>65,704,000.00</b>	<b>60,504,120.34</b>	<b>5,199,879.66</b>	<b>92.09</b>
210301	Гэрэл, цахилгаан	53,004,000.00	46,207,828.34	<b>6,796,171.66</b>	<b>87.18</b>
210302	Түлш, халаалт	4,000,000.00	5,500,000.00	<b>-1,500,000.00</b>	<b>137.50</b>
210303	Цэвэр, бохир ус	8,700,000.00	8,796,292.00	<b>-96,292.00</b>	<b>101.11</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,291,500.00</b>	<b>51,400,245.73</b>	<b>891,254.27</b>	<b>98.30</b>
210401	Бичиг хэрэг	16,000,000.00	16,175,890.00	<b>-175,890.00</b>	<b>101.10</b>
210402	Тээвэр, шатахуун	13,407,500.00	13,800,000.00	<b>-392,500.00</b>	<b>102.93</b>
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,000,000.00	12,267,755.73	<b>1,732,244.27</b>	<b>87.63</b>
210404	Ном, хэвлэл	2,184,000.00	1,176,000.00	<b>1,008,000.00</b>	<b>53.85</b>
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	300,000.00	375,000.00	<b>-75,000.00</b>	<b>125.00</b>
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,400,000.00	7,605,600.00	<b>-1,205,600.00</b>	<b>118.84</b>
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>658,000.00</b>	<b>158,000.00</b>	<b>500,000.00</b>	<b>24.01</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	658,000.00	158,000.00	<b>500,000.00</b>	<b>24.01</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,000,000.00</b>	<b>23,995,805.00</b>	<b>4,195.00</b>	<b>99.98</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,000,000.00	11,996,205.00	<b>3,795.00</b>	<b>99.97</b>
210604	Урсгал засвар	12,000,000.00	11,999,600.00	<b>400.00</b>	<b>100.00</b>
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,508,000.00</b>	<b>14,349,600.00</b>	<b>2,158,400.00</b>	<b>86.93</b>
210702	Дотоод албан томилолт	16,508,000.00	14,349,600.00	<b>2,158,400.00</b>	<b>86.93</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,849,600.00</b>	<b>9,387,628.00</b>	<b>3,461,972.00</b>	<b>73.06</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,000,000.00	7,596,821.00	<b>3,403,179.00</b>	<b>69.06</b>
210803	Даатгалын үйлчилгээ	1,568,600.00	1,568,600.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210804	Тээврийн хэрэгслийн татвар	145,000.00	137,220.00	<b>7,780.00</b>	<b>94.63</b>
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	66,000.00	66,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
210807	Газрын төлбөр	70,000.00	18,987.00	<b>51,013.00</b>	<b>27.12</b>
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>650,000.00</b>	<b>650,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	650,000.00	650,000.00	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>210,719,000.00</b>	<b>102,968,677.00</b>	<b>107,750,323.00</b>	<b>48.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>210,719,000.00</b>	<b>102,968,677.00</b>	<b>107,750,323.00</b>	<b>48.87</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	208,719,000.00	101,168,677.00	<b>107,550,323.00</b>	<b>48.47</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,800,000.00	<b>200,000.00</b>	<b>90.00</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,027,449,600.00</b>	<b>1,903,450,174.68</b>	<b>123,999,425.32</b>	<b>93.88</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,027,449,600.00</b>	<b>1,903,450,174.68</b>	<b>123,999,425.32</b>	<b>93.88</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,027,449,600.00	1,903,450,174.68	<b>123,999,425.32</b>	<b>93.88</b>
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>93</b>	<b>85</b>	<b>8</b>	<b>91.40</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>5</b>	<b>5</b>	<b>0</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	5	5	<b>0</b>	<b>100.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>44</b>	<b>40</b>	<b>4</b>	<b>90.91</b>
620001	Удирдах ажилтан	5	5	<b>0</b>	<b>100.00</b>
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	<b>0</b>	<b>100.00</b>
620003	Үйлчлэх ажилтан	4	3	<b>1.00</b>	<b>75.00</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>44</b>	<b>40</b>	<b>4</b>	<b>90.91</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	19	18	<b>1</b>	<b>94.74</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	10	<b>1</b>	<b>90.91</b>
650012	Шүүгч, прокурор	14	12	<b>2</b>	<b>85.71</b>

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газар /цаашид Шүүхийн Тамгын газар гэх/ нь “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүн таслах ажиллагааг хэвийн, тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж, шүүхийн үйлчилгээг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй хүргэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулжээ.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөц, шүүхийн судалгаа, мэдээлэл, олон нийтийг мэдээллээр хангах зэрэг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах,
- Шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих,
- Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх,
- Шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах,
- Шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах,
- Хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Шүүхийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Шүүхийн Тамгын газрын санхүүгийн үйл ажиллагаанд ШЕЗ-ийн Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албанаас хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд ШЕЗ-ийн даргын 2023 оны 5 дугаар сард баталсан “ШЕЗ-ийн даргын эрхлэх хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд дурдагдсан алдаа, зөрчил, ҮАГ-аас өгсөн зөвлөмж, албан шаардлагын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-ий дагуу шилэн дансны хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, мэдээллийн ил тод байдлыг хангах арга хэмжээний хүрээнд дансны хуулгыг шилэн дансны мэдээлэлтэй тулган дотоод хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШЕЗ-ийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар ШЕЗ-ийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газрын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18,351.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	40.0	14,040.0	14,000.0
Авлага	-	-	-
Бараа материал	13,662.2	20,097.3	6,435.2
Үндсэн хөрөнгө	1,158,882.8	1,120,096.1	(38,786.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,172,585.0</b>	<b>1,154,233.5</b>	<b>(18,351.5)</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,172,585.0	1,154,233.5	(18,351.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,172,585.0</b>	<b>1,154,233.5</b>	<b>(18,351.5)</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 14,040.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ШЕЗ-өөс өгсөн чиглэлийн дагуу цалингийн сангаас 14,000.0 мянган төгрөгийг Ахмадын сангийн 100130005501 тоот дансанд төвлөрүүлснээс,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,120,096.1 мянган төгрөг болж, 38,786.7 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2023 оны “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай” 421 дүгээр тогтоолын дагуу ашиглалтын хугацаа дууссан 84,592.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийн үнийг шинэчлэн тогтоож, 43,647.4 мянган төгрөгөөр данс бүртгэлд тусгаснаас голлон шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг /улсын төсвөөс/ 2,472,878.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 259,260.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 351,518.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 28,606.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 23,871.9 мянган төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 125,951.1 мянган төгрөгөөр зэрэг нийт 796,083.2 мянган төгрөгөөр бууруулж, 1,676,795.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголоор цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос олгох НДШ-ийн зардлыг 119,799.5 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 10,508.0 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 208,719.0 мянган төгрөг зэргээр батлагдсан төсвийг нийт 350,654.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,027,449.6 мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,027,449.6 мянган төгрөгийн төсөв баталж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,027,449.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,919,699.3 мянган төгрөг буюу 94.7 хувьтай тайлагнагдсан нь ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэгийг Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9<sup>1</sup>-д зааснаар буюу **авч байсан сарын дундаж цалингийн** хэмжээгээр тэтгэмжийг тооцож, төлөвлөсөн боловч Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу **үндсэн цалингийн** дунджаас тооцож олгосноос шалтгаалан 107,750.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,812,730.6	1,812,730.6	-	100.0
2	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	4,000.0	4,000.0	-	100.0
3	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	210,719.0	102,968.7	(107,750.3)	48.9
	<b>Дүн</b>	<b>2,027,449.6</b>	<b>1,919,699.3</b>	<b>(107,750.3)</b>	<b>94.7</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус газрын нэмэлт санхүүжилтийн 100130005401 тоот дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

<sup>1</sup> Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.9-д “Шүүгчийг өндөр насны тэтгэвэрт гарахад түүний авч байсан сарын дундаж цалингийн хэмжээгээр 36 сарын хугацаагаар тооцож нэг удаагийн тэтгэмж олгоно.”.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,466,202.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,662.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор тус байгууллага нь бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг цахим хэлбэрт шилжүүлж шуудан холбооны зардлыг хэмнэсэн, шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй, байгууллагын гэрэл, цахилгааны хэрэглээг хэмнэсэн зэргээр төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, баталсан төсвийн хүрээнд ил тод байдлыг ханган ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шүүхийн Тамгын газрын мэдээлбэл зохих 28 төрлийн 168 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 123 дугаар “Санхүүгийн тайланд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримттай холбоотой 1,595.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	1	1,595.3	1	1,595.3	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>1,595.3</b>	<b>1</b>	<b>1,595.3</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **17,478.4** мянган төгрөгийн зөрчил илэрснээс **3,478.4** мянган төгрөгийн албан шаардлага, **14,000.0** мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

### 5.1 Албан шаардлага:

1. Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлийн дагуу албан хаагчдад урамшуулал олгох төсвийн тооцооллыг урьдчилан хянаагүйн улмаас цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлаас ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд **3,478.4** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “*Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гарган, төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь “... байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах ...”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэсэн заалтын дагуу Ахмадын сангийн эх үүсвэрийг төсөвт тусган төлөвлөөгүйгээс жилийн эцэст цалингийн зардлаас **14,000.0** мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130005501 дугаар дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалтыг хэрэгжүүлэн тухайн жилийн төсвийн төлөвлөгөөнд “Ахмадын сан”-ийн зардлыг тусган, батлуулах.

Дээрх **зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг** Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup>-д заасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>2</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж			
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Залруулсан			Залруулаагүй		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо	Дүн	
Дүн														

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Тоо	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан.	1	3,478.4			1	3,478.4						
Ахмадын санд шаардагдах хөрөнгийг төлөвлөөгүй.	1	14,000.0					1	14,000.0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>17,478.4</b>			<b>1</b>	<b>3,478.4</b>	<b>1</b>	<b>14,000.0</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төо		Дүн			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
<b>Дүн</b>										
<b>Нийт дүн</b>										

/мянган төгрөгөөр/